



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Спортын бэлтгэлийн төв”-ийн ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/6/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас:70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn</p> <p>Аудитор: Утас: 70342716 Цахим хаяг:</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6-11
3. Аудитын тайлан.....	11-14
3.1 Ерөнхий зүйл.....	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Материаллаг байдал.....	
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
4. Аудитын илрүүлэлт.....	14-16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.03.07 № 125
тантай _____ ны № _____ т

“СПОРТЫН БЭЛТГЭЛИЙН ТӨВ”-
ИЙН ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
О.БАЯРБАТ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Спортын бэлтгэлийн төв”-ийн ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Спортын бэлтгэлийн төв”-ийн ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


D:\koinhereg\2022A\exam

006020756

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:\bioligheng\2022\A4\tool

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		<u>81,268,528.15</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
31110	Төгрөг	292,421.00	1,938,064.20
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		
3121	Төгрөг		
31213	Арилжааны банк дахь харилцах	10,356,297.05	11,067,071.95
33	АВЛАГА		
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,337,522.80	-
33401	Дансны авлага /ТӨҮГ/	337,522.80	
		1,000,000.00	
34	УРЬДЧИЛГАА		
3471	Урьдчилгаа тооцоо		
34713	Цалингийн урьдчилгаа	-	971,800.00
		-	971,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ		
351	Түүхий эд материал		
35110	Тусгай зориулалттай материал		67,291,592.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	17,935,012.64
354	Хангамжийн материал		
35410	Бичиг хэргийн материал	22,145,871.82	4,227,618.18
35420	Аж ахуйн материал	58,000.00	174,863.64
35430	Сэлбэг хэрэгсэл	5,365,193.82	
35450	Барилгын засварын материал		670,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,164,000.00	3,382,754.54
		15,558,678.00	-

2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	756,638,294.75	692,381,485.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	756,638,294.75	692,381,485.23
392	Биет хөрөнгө	756,516,568.75	691,323,092.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,306,326,858.03	1,306,326,858.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	644,809,176.00	682,842,639.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	78,950,000.35	78,950,000.35
39204	Хуримтлагдсан элэгдэл	72,381,670.00	73,976,670.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,979,720.00	82,979,720.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	78,583,824.00	79,068,694.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	126,569,946.73	126,569,946.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	94,130,164.00	105,691,644.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	120,301,072.64	120,301,072.64
39215	Хуримтлагдсан элэгдэл	68,706,195.00	82,224,856.80
393	Биет бус хөрөнгө	121,726.00	1,058,392.69
39301	Програм хангамж	710,000.00	1,910,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	588,274.00	851,607.31
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	790,770,407.42	773,650,013.38
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	149,501,906.61	78,763,651.34
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	149,501,906.61	78,763,651.34
413	Өглөг	149,501,906.61	78,763,651.34
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	22,042,041.00	22,836,147.23
4136	Бусад өглөг	127,459,865.61	55,927,504.11
41361	Байгууллагад төлөх өглөг	3,080,000.00	-
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	65,120,394.89	25,976,919.97
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	28,293,490.48	14,199,801.14
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	30,965,980.24	15,750,783.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	641,268,500.78	694,886,362.04
51	Засгийн газрын хувь оролцоо	641,268,500.78	694,886,362.04

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,237,758,937.84	1,237,758,937.84
51101	Өмч: - төрийн	1,237,758,937.84	1,237,758,937.84
512	Хуримтлагдсан үр дүн	(431,587,673.06)	(542,872,575.80)
51210	Өмнөх үеийн үр дүн	(380,450,371.07)	(596,490,437.06)
51220	Тайлант үеийн үр дүн	(51,137,301.99)	53,617,861.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	(164,902,764.00)	
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	790,770,407.39	<u>773,650,013.38</u>

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	156,018,181.82	171,636,462.43
11	ТАТВАРЫН ОРЛОГО	156,018,181.82	171,636,462.43
110	Орлогын албан татвар	156,018,181.82	171,636,462.43
1100	Хувь хүний орлогын албан татвар	156,018,181.82	171,636,462.43
110002	Үйл ажиллагааны орлого	156,018,181.82	171,636,462.43
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	207,155,483.81	167,653,737.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	207,155,483.81	167,653,737.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	207,155,483.81	167,653,737.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,713,820.00	49,036,524.00
210101	Үндсэн цалин	30,608,000.00	49,036,524.00
210105	Гэрээт ажлын хөлс	19,105,820.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,434,261.00	14,663,672.20
210301	Гэрэл, цахилгаан	15,274,261.00	14,663,672.20
210304	Байрны түрээс	2,160,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	4,700,504.00	3,997,323.82

210401	Бичиг хэрэг	21,182.00	61,254.55
210402	Тээвэр, шатахуун	4,383,095.00	3,655,811.09
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	296,227.00	280,258.18
2107	Томилолт, зочны зардал	1,262,200.00	368,836.36
210702	Дотоод албан томилолт	1,262,200.00	368,836.36
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	134,044,698.81	99,587,381.10
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	53,860.00	7,300.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	128,771,848.81	94,242,204.29
210813	Бусад зардал /ТӨҮГ/	5,218,990.00	5,337,876.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(51,137,301.99)</u>	<u>3,982,724.95</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(51,137,301.99)</u>	<u>3,982,724.95</u>

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>114,291,000.00</u>	<u>207,616,777.27</u>
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>163,688,177.80</u>	<u>128,734,290.17</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>163,688,177.80</u>	<u>128,734,290.17</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,485,529.80	39,778,077.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	45,485,529.80	39,778,077.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,539,000.00	4,897,667.12
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	36,539,000.00	4,897,667.12
2104	Хангамж, бараа материалын зардал	67,450,388.00	6,762,776.00
210402	Тээвэр, шатахуун	4,947,818.00	6,762,776.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	62,502,570.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,213,260.00	77,295,770.05

210815	Хүүний төлбөрт төлсөн /ТӨҮГ/	1,481,600.00	1,792,000.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	5,472,800.00	61,558,905.96
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	7,258,860.00	13,944,864.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(49,397,177.80)</u>	<u>78,882,487.10</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	60,245,000.00	-
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	60,245,000.00	
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,639,000.00	1,200,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,200,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		1,200,000.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	4,639,000.00	
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		1,200,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>55,606,000.00</u>	<u>(1,200,000.00)</u>
14	Бусад эх үүсвэр	3,500,000.00	8,000,000.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,500,000.00	8,000,000.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	3,500,000.00	8,000,000.00
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	3,500,000.00	8,000,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	6,208,822.20	77,682,487.10
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,439,895.85	10,648,718.05
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,648,718.05	13,005,136.15

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,237,758,937.84		-380,450,371.07		857,308,566.77
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,237,758,937.84		-380,450,371.07		857,308,566.77

C07	Тайлант үеийн үр дүн			-216,040,065.99		(216,040,065.99)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,237,758,937.84		-596,490,437.06		641,268,500.78
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,237,758,937.84		-596,490,437.06		641,268,500.78
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,237,758,937.84		-596,490,437.06		641,268,500.78
D08	Тайлант үеийн үр дүн			53,617,861.26		53,617,861.26
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,237,758,937.84		-542,872,575.80		694,886,362.04

2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Эдийн засгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	2020	2021		Заруу	Хувь
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	мян.төг	144,476.00	220,000.00	207,616.00	(12,384.00)	94.37%
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	144,476.00	220,000.00	46,440.00	(173,560.00)	21.11%
	Бусад орлого	мян.төг			161,176.00	161,176.00	
2	Нийт зардал	мян.төг	199,072.00	188,433.10	204,060.00	15,626.90	108.29%
3	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	19,009.40	18,500.00	19,856.30	1,356.30	107.33%
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	(54,596.00)	31,566.90	3,556.00	(28,010.90)	11.26%
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	-	10,000.00	3,200.40	(6,799.60)	32.00%
6	Төсвийн төлбөрт	мян.төг	5,472.80	21,566.90	61,558.00	39,991.10	285.43%
8	Нийт ажиллагсдын тоо	мян.төг	7.00	10.00	7.00	(3.00)	70.00%
9	Нийт цалингийн сан	хүн	50,178.20	77,436.70	40,028.00	(37,408.70)	51.69%
10	Дундаж цалин	мян.төг	597.40	645.30	476.52	(168.78)	73.85%
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	1.40	0.90	0.98	0.08	109.21%
12	Нийт авлага	төг	26,560.00	0	0	0	0.00%
13	Нийт өглөг	мян.төг	27,400.00	10,000.00	78,763.00	68,763.00	787.63%
14	Үүнээс: Богино хугацаат өр төлбөр	мян.төг	27,400.00	10,000.00	78,763.00	68,763.00	787.63%

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Спортын бэлтгэлийн төв”-ийн ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц

бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

“Спортын бэлтгэлийн төв”-ийн ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 22-ны өдрийн А/2-1 албан тоотой ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Спортын бэлтгэлийн төв”-ийн ТӨААТҮГ-ын зорилго, зорилт нь “Монгол Улсын биеийн тамир спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогод тусгасан зорилт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулилтыг хийхэд ая тухтай нөхцөл бололцоогоор хангах, хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэхэд” оршдог байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй болно. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Спортын бэлтгэлийн төв”-ийн ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлогын 770.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 15.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 12.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг шинэчлэн тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 773.6 сая төгрөгийн 2 хувь буюу 12.4 сая төгрөг байхаар шинэчлэн тогтоож ажиллалаа. Учир нь өмнөх оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн дүн багассан учир шинэчлэн тогтоох шаардлага үүссэн болно.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

“Спортын бэлтгэлийн төв”-ийн ТӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна. Үүнд: Санхүү байдлын, Үр дүнгийн, Мөнгөн гүйлгээний, Өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлагыг зэргийг тодруулж тайлагнасан болно.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

“Спортын бэлтгэлийн төв”-ийн ТӨААТҮГ нь 2021 онд өөрийн орлогыг 220.0 сая төгрөгөөр, 10 орон тоогоор үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тус “Спортын бэлтгэлийн төв”-ийн ТӨААТҮГ нь 2021 он үйлчилгээ үзүүлсэний орлогоос 46.4, бусад орлогоос 161.2 сая төгрөг буюу нийт 207.6 сая төгрөгийн орлого олж гүйцэтгэлээр 194.6 сая төгрөгийг зарцуулж 13.0 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

Байгууллагын орлого, гүйцэтгэлийг 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлээр харуулсан болно.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны гүйлгээ гараагүй болно.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

“Спортын бэлтгэлийн төв”-ийн ТӨААТҮГ нь ТӨБЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 643 тоот тогтоолын хавсралтаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөг төлөвлөн батлуулсан байна.

Уг төлөвлөгөөг зардлын гүйцэтгэлээр харьцуулбал: 2021 онд нийт зардлыг 188.4 сая төгрөгөөр төлөвлөсөн нь гүйцэтгэлээр 204.1 сая төгрөгийг зарцуулж 15.7 сая төгрөгийн илүү зарцуулалт хийгдсэн байна. Үүнд: Шуудан холбооны зардалд төлөвлөснөөс 0.2, бараа материал худалдан авах зардал 21.0, урсгал зардал 15.8 сая төгрөгөөр тус хэтэрсэн ч цалингийн зардлыг 30.7 сая төгрөгөөр хэмнэж дээрх зардлуудад зарцуулснаар илэрхийлэгдэж байна.

Тус газар нь 2021 онд 1.2 сая төгрөгийн программ хангамжийг шинэчилж, бараа материалын эцсийн үлдэгдлийг өмнөх оноос 45.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж ажилласан байна.

Тухайн жилийн ашиг алдаглыг орлого үр дүнгийн тайлангаас үзэхэд 3.9 сая төгрөгийн ашиг алдагдалтай ажилласнаар тайлагнаж, авлагын үлдэгдлийг 0.9, өглөгийн үлдэгдлийг 78.7 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тус тус тайлагнажээ.

Өглөгийн үлдэгдлээс 2016 оноос хойш үүссэн нийт 18.4 сая төгрөгийн өглөг нь эзэн холбогдолгүй өглөг байна.

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй алдаа зөрчил илрээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

“Спортын бэлтгэлийн төв”-ийн ТӨААТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж ажиллахдаа аудитын төлөвлөлтийн үе шатанд сонгосон нийт 10 эрсдлийн хүрээнд горим сорилыг хэрэгжүүлж ажиллалаа.

Хэрэгжүүлсэн горим сорилоор хүнсний орлого, зарлагыг тусгай зориулалтын данс бүртгэлд бүртгэж тайлагнасан, 2021 онд зарцуулсан шатахуун зарцуулалтын тайлан гаргаагүй,

жолоочийн тооцооны замын хуудас огт хөтлөөгүй, албан томилолтын хуудас, удирдамж, тайлан байхгүйгээр томилолтын зардал олгосон, бэлэн мөнгө зарцуулахдаа даргын цохолтгүй, гарын үсэггүй зарцуулсан, цаашид ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийг актлаж, устгаагүй, данс бүртгэлээс хасаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчлүүд илэрч байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд 2021 онд мэдээлэх 136 мэдээлээс 34 мэдээлийг хугацаа хоцроосон, мөн тушаал шийдвэртэй холбоотой 2721111 төгрөгийн мэдээллийг огт мэдээлээгүй зөрчил илэрлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу мэдээлгүй хугацаа хоцроож мэдээлсэн, огт мэдээлээгүй байгаа нь шалгуурт нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 5 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хүргүүлж ажилласан ч алдаа зөрчил илэрч байгаа нь зөвлөмжийн биелэлтийг хангалтгүй биелүүлсэн гэж дүгнэгдэж байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өглөгийг эзэн холбогдолгүйгээр тайлагнасан нь байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул гэж илэрхийлэгдэж байгаа тул шинээр үүссэн өглөг, авлагыг дараагийн аудитаар шалгах асуудалд оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 8.5 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 6.6 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгч ажиллалаа.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

1. Тус газар нь 2021 онд албан томилолтын зардал олгохдоо томилолтын хуудасгүй, удирдамж, тайлан байхгүй, анхан шатны баримтгүйгээр 305720 төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Тус газар нь 2021 онд 5761811.09 төгрөгийн шатахуун зарцуулсан боловч жолоочийн тооцооны замын хуудас огт хөтлөөгүй, хэн хаашаа явсан нь тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахууны тайлан гаргаж тайлагнаагүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага бичлээ.

2. Тус газар нь 2021 онд шилэн дансанд мэдээлэх мэдээлээс 2721111 төгрөгийн байгууллагын даргын тушаал шийдвэртэй холбоотой мэдээллүүдийг мэдээлээгүй нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага бичлээ.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Кассын тайлантай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Бэлэн мөнгө зарцуулахдаа бэлэн мөнгө хүссэн өргөдөлд даргын цохолтгүй, гарын үсэггүйгээр 6.6 сая төгрөгийг зарцуулсан.

1.2 Өгсөн зөвлөмж

Бэлэн мөнгө хүссэн өргөдлийг бүрэн бөглөж анхан шатны баримтын бүрдлийг бүрэн бүрдүүлж ажиллах.

2. Шатахууны зардалтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Шатахууны орлого зардлыг бараа материалын тодруулга тайланд бүрэн тусгаж тайлагнаагүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж

Шатахууны зардалыг бүрэн тусгаж УСНББОУС 12- Бараа материал хэсгийн 4 дүгээр зүйлийн 4.16 “Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Тухайн жил үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийж тоолоогоор цаашид ашиглах боломжгүй болосон хөрөнгүүдийг актлаж устгах санал гарсан ч жилийн эцэст тус хөрөнгүүдийг актлаж утсгаагүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж

Цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгүүдийг жагсаалт үйлдэн дор бүр нь холбогдох газарт мэдэгдэн үндсэн хөрөнгийн данс бүртгэлээс хасах хөдөлгөөнийг хийж ажиллах.

4. Хүнсний зардалтай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Хүнсний орлого зарлагыг тусгай зориулалтын материалын орлого, зарлагаар бүртгэж тайлагнасан.

4.2 Өгсөн зөвлөмж

Сангийн сайдын 388 дугаар тушаалын хавсралтаар баталсан НББ-ийн дансны заавар хэсгийн 3.5. “Төсвийн зардлыг одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомж, сангийн яамнаас гаргасан дансны нэгдсэн жагсаалтын дагуу ангилан бүртгэнэ.” гэсний дагуу ангилан бүртгэж хэвших.

5. Өглөгтэй холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Цалингийн өглөг дансанд 18.4 сая төгрөгийн өглөг нь эзэн холбогдолгүй өглөг бүртгэлтэй байна.

5.2 Өгсөн зөвлөмж

Цаашид тухайн өглөгийг данс бүртгэлээс хасах арга хэмжээг авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая/төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Спортын бэлтгэлийн төв	8	15.4	0	0	1	0.3	2	8.5	5	6.6

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу -ын 20... оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёр дугаар газрын /... аудит ХХК-ийн/..... ахлах аудитор ..., аудитор ... нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер , газрын захирал, тэргүүлэх аудитор нар тус тус хэрэгжүүлсэн.

..... 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 20... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөтэй/үр нөлөөгүй** байна гэж үзсэн. /үр нөлөөгүй бол шалтгааныг дурдах/

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн/**нийцээгүй**, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт **тохирсон/тохироогүй** байна. /**нийцээгүй болон тохироогүй байвал шалтгааныг дурдах/**

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудитын тайлант оны ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитор оос шууд туслалцаа авах **шаардлагагүй/шаардлагатай** гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

..... 20... оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл/мөнгөн** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр ... сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл ... гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг ... хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 20... оны ... -ын ... сая төгрөгөөс ... хувиар буюу сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох **шаардлагатай/шаардлагагүй** гэж үзсэн. /шинэчлэн тогтоосон бол тайлбар хийх/

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

..... байгууллага нь тайлант онд нийт мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллийг ил тод байршуулаагүй, мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

/Дээрх хуулиас гадна, тухайлбал ТБОНӨХБАҮХА тухай хууль зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан асуудал байвал гарсан зөрчил, шийдвэрлэсэн байдлыг дурдах/

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн/нийцээгүй, /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн/нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад сая төгрөгийг залруулж, сая төгрөгийн зөрчлийг арилгасан, сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар сая төгрөгийн зөрчилдтөлбөрийн акт, сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгснөөс акт ... хувь, албан шаардлага ... хувь, зөвлөмж..... хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж							
Нийт дүн							

.....хэрэгжилт хангалтгүй байна. ... Алдаа, зөрчил давтан гарсан асуудалд ... төлбөрийн акт/албан шаардлага тогтоохоор/ хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт ... сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, ... сая төгрөгийн алдааг залруулж, ... сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, ... сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, ... сая төгрөгийн алдаа зөрчилд ... зөвлөмж өгсөн. /Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал байвал дурдах/

Залруулагдаагүймянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон мянган төгрөгийн түвшинээс мянган төгрөгөөс /их/ бага/ байгаа тул Хязгаарлалттай/ Зөрчилгүй..... дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой сая төгрөгийн ... алдааг залрууллаа. Үүнд:

-
-
-

8.2 Төлбөрийн акт

.....

8.3 Албан шаардлага

.....

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

2. холбоотой асуудал

Илрүүлэлт:

Өгсөн зөвлөмж:

3. холбоотой асуудал

Илрүүлэлт:

Өгсөн зөвлөмж:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

